



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Удирдлагын академийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 5,232,000.00 (таван сая хоёр зуун гучин хоёр мянган) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргаанд хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Удирдлагын академийн захирал Д.Сүрэнчимэг, Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын бүсийн захиргааны захирал Б.Бат-Орших нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, засаж сэлбэн ашиглах, үнийг шинэчлэн тогтоож данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

137884556
7-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн
2.7 дугаар тогтоолын хавсралт



Удирдлагын академийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй
Хөдөө аж ахуйн Халх гол үндэсний бүтээн байгуулалтын
бүсийн захиргаанд балансаас балансад шилжүүлэх автомашины жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Ландкрузер-100, 1828 УБЗ, арал№ UZJ1000076315	2000/ 2008	5,232,000.00	5,232,000.00	00
	Нийт дүн		5,232,000.00 (таван сая хоёр зуун гучин хоёр мянга)	5,232,000.00 (таван сая хоёр зуун гучин хоёр мянга)	00